

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргагүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатаанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5.	Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙН
ЗАХИРАЛ У.САРАНТУЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/239
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дүрслэх урлагийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дүрслэх урлагийн музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал У.Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор О.Цэндхүү чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудитор М.Батмагнай, аудиторын туслах М.Сэржмядаг, Д.Эрдэнэбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дүрслэх урлагийн музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дүрслэх урлагийн музей нь 1966 онд анх үүсгэн байгуулагдсан. Анх үүсгэн байгуулагдахдаа 300 гаруй үзмэртэй нээгдсэн бол одоогийн байдлаар 16809 нэгж бүхий сан хөмрөгтэй, 12 танхимтай үйл ажиллагаагаа явуулж байна. 1995 онд уг музейг Г.Занабазарын нэрэмжит болгосон байна.

Дүрслэх урлагийн музей нь "Монголын дүрслэх урлагийн зууны шилдэг зураач, урчуудын бүтээл туурвилын сор, дахин давтагдашгүй үзмэрүүдийг дотоод гадаадын үзэгчдэд дэлгэн толилуулж, судалгааны гүнзгий үндэслэлтэйгээр тайлбарлан таниулахын зэрэгцээ хадгалан хамгаалах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд эрхэлдэг, үндэсний соёл урлагийн эрхэмсэг байгууллага байхад оршино" гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2009 онд батлагдсан Улс, орон нутгийн музейн дүрмийн 1.2-д зааснаар Дүрслэх урлагийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 2009 онд батлагдсан Улс, орон нутгийн музейн дүрмийн 1.2-д Музей нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, таашаал хүртээх зорилгоор хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх;

- Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, арвижуулах ажиллагаа

Дүрслэх урлагийн музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дүрслэх урлагийн музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Соёлын тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дүрслэх урлагийн музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дүрслэх урлагийн музей нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Дүрслэх урлагийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дүрслэх урлагийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 19 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус музей нь төрийн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага тул нийт зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 501,702.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10,034.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь музейн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ бага учир эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 22 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 16 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	3,285.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	454.8	
	Дүн	3	3,739.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Ээлжийн амралтын тооцоог давтан шалгахад 18 ажилтанд 454.8 мянган төгрөг илүү олгосон.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчимтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/648 тоот тушаалаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх комиссыг томилон 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2019 оны 03 сарын 31-ний өдөр дуусгахаар заасан байна. Дүрслэх урлагийн музейд 2018 оны жилийн эцсийн байдлаар 10008 дэсийн 16809 ширхэг 26,773,960.5 мянган төгрөгийн үзмэр хадгалагдаж байна. Музейн тооллогын комисс 2018 оны 11 сарын 30-ны өдрөөс эхлэн ажиллаж 2019 оны 02 сарын 14-ны өдрийн байдлаар түүх соёлын дурсгалт зүйлээс 7105 дэсийн 10251 ширхэг үзмэр тоолж тооллогын гүйцэтгэл 71.0 хувьтай байна.

2018 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Сангийн яамны харилцах данснаас 7,070.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ "улсын төсвөөс өгөх өглөг" утгатайгаар музейн харилцах дансанд төвлөрсөн. Тус гүйлгээг санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд "Бусад орлого"-оор бүртгэж, засгийн газрын дотоод шилжүүлгээр буцаан төвлөрүүлсэн дүнд тайлагнасан. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн

орлого, зарлагын гүйлгээг тохируулгын тайлангаар цэвэрлэсэн тул бусад орлого болон төвлөрүүлэх шилжүүлгийн дүн тухайн дүнгээр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дүрслэх урлагийн музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 377,553.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт 409,647.1 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого төвлөрүүлснээс 397,051.5 мянган төгрөгийн зарцуулалт гаргаж, 12,595.6 мянган төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлсэн.

2018 онд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 70,786.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 102,978.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 32,191.5 мянган төгрөгийн орлогыг давуулан биелүүлсэн байна. Давсан орлогоос 28,403.0 мянган төгрөгийг Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 275 тоот тушаалаар батлагдсан "Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай" журмын дагуу нэмэлт санхүүжилтийн 100900035413 тоот дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дүрслэх урлагийн музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулахад нийт 3 ангилал бүхий 20 төрлийн 148 мэдээлэл оруулахаас 148 мэдээллийг иж бүрэн байршуулсан. Мөнгөн хөрөнгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээг бүрэн байршуулсан эсэхийг шалгахад 12 гүйлгээгээр 316,764.4 мянган төгрөгийн орлогын, 2 гүйлгээгээр 36,602.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн байршуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай биелэгдсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дүрслэх урлагийн музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дүрслэх урлагийн музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Музейн үзмэрийн танхимын түрээсийн орлогод 12 харилцагчаас 10,950.0 мянган төгрөг төвлөрсөн боловч түрээсийн орлогууд нь тогтмол биш 2 цагаас 7 өдрийн хугацаагаар түрээслүүлсэн гэсэн шалтгаанаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын гэрээний үлгэрчилсэн загварыг ашиглаагүй, 30 хувь буюу 3,285.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам”-ын 13-т “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно” 19-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байх үүрэгтэй” мөн ТӨБЗГ-ын 2016 оны 10 сарын 20-ны 102 тоот тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож 2017 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Түрээсийн гэрээг байгуулаагүй байх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт орлого төвлөрүүлээгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам"-ыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оноос түрээсийн төлбөрийн 30 хувийг шилжүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 2,242,477.2 мянган төгрөгөөр тусгагдсан, санхүүгийн байдлын тайланд засгийн газрын оруулсан капиталын дүн 2,372,812.2 мянган төгрөгөөр тусгагдаж 130,335.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь "бодитой оршин байх ба тохиолдсон байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан "Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2-д "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ" 8.2.3-д "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Засгийн газрын оруулсан капитал нь улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд өөрийн хөрөнгийн хэмжээг үнэн зөв тусгах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээг 2,372,335.0 мянган төгрөг болгон өөрчлүүлэхээр улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичгээр хандаад байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,657,618.56	92,009,695.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	1,887,900.00	14,594,000.00
335	Бусад авлага	1,887,900.00	14,594,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,887,900.00	14,594,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	87,769,718.56	77,415,695.00
354	Хангамжийн материал	87,769,718.56	77,415,695.00
35410	Бичиг хэргийн материал	746,308.00	1,337,117.00
35420	Аж ахуйн материал	35,260,984.00	37,924,895.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	379,890.00
35450	Барилгын засварын материал	1,959,530.00	2,964,950.00
35470	Бусад хангамжийн материал	49,602,896.56	34,808,843.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,921,516,934.21	27,961,636,054.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,921,516,934.21	27,961,636,054.61
392	Биет хөрөнгө	26,921,516,934.21	27,874,792,854.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,158,911,520.00	1,014,405,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-931,514,717.88	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,850,000.00	7,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,850,000.00	-7,850,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	203,501,589.15	210,009,185.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,955,661.87	-163,646,421.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,053,946.80	101,616,946.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,251,748.99	-70,530,492.80
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	26,575,272,500.00	26,773,960,500.00
39217	Ном	8,499,507.00	8,977,237.00
393	Биет бус хөрөнгө	00.00	86,843,200.00
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	-385,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	86,843,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	27,011,174,552.77	28,053,645,749.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	182,230.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	182,230.00	00.00
413	Өглөг	182,230.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	182,230.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,010,992,322.77	28,053,645,749.61
51	Засгийн газрын хувь оролцоо	27,010,992,322.77	28,053,645,749.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,285,969,025.00	2,372,812,225.00
51101	Өмч: - төрийн	2,285,969,025.00	2,372,812,225.00
512	Хуримтлагдсан үр дүн	-200,636,543.23	-53,480,745.91
51210	Өмнөх үеийн үр дүн	-200,636,543.23	-200,636,543.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	147,155,797.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,925,659,841.00	25,734,314,270.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	27,011,174,552.77	28,053,645,749.61

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	313,223,951.52	659,917,308.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,601,612.52	312,248,848.00
120	Нийтлэг татварын бус орлого	98,601,612.52	312,248,848.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,601,612.52	305,178,848.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,019,740.00	103,289,494.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,029,962.52	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,551,910.00	201,889,354.00
120009	Бусад орлого	00.00	7,070,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	214,622,339.00	347,668,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	208,923,250.00	306,766,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	208,923,250.00	306,766,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	40,902,060.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,498,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	28,404,060.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,699,089.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	301,438,877.23	514,028,787.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,438,877.23	514,028,787.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,063,427.23	486,453,262.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,293,096.20	274,443,744.50
210101	Үндсэн цалин	177,456,040.20	192,738,982.90
210102	Нэмэгдэл	00.00	47,467,956.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,835,656.00	18,080,100.00
210104	Урамшуулал	00.00	16,156,705.60
210105	Гэрээт ажлын хөлс	4,001,400.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,286,066.47	33,043,312.71
210201	Тэтгэврийн даатгал	13,419,849.39	22,135,714.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,887,914.08	3,122,086.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839,741.00	2,124,305.00
210204	Ажилгүйдлийн даатгал	376,233.00	512,692.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,762,329.00	5,148,515.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,459,032.40	23,145,463.19
210301	Гэрэл, цахилгаан	6,540,983.40	11,244,775.80
210302	Түлш, халаалт	6,453,672.00	11,069,248.00
210303	Цэвэр, бохир ус	464,377.00	831,439.39
2104	Хангамж, бараа материалын зардал	3,993,431.98	6,665,513.15

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	372,270.00	872,904.00
210402	Тээвэр, шатахуун	1,208,520.00	1,619,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,124.98	1,410,970.15
210404	Ном, хэвлэл	00.00	104,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	870,313.00	1,711,765.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	538,204.00	945,354.00
2105	Нормативт зардал	00.00	2,425,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,425,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,039,710.00	11,382,480.00
210604	Урсгал засвар	3,039,710.00	11,382,480.00
2107	Томилолт, зочны зардал	560,000.00	1,587,000.00
210702	Дотоод албан томилолт	560,000.00	1,587,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,824,828.22	13,953,785.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,059,392.22	11,207,969.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,320.00	1,348,200.00
210807	Газрын төлбөр	236,016.00	236,016.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	26,800.00	32,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,607,261.96	119,806,163.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,917,467.00	60,063,051.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,689,794.96	59,743,112.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,375,450.00	27,575,525.45
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	19,976,825.45
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	19,976,825.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,375,450.00	7,598,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,375,450.00	7,598,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11,785,074.29</u>	<u>145,888,520.32</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	230,000.00	3,139,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	230,000.00	3,139,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,871,723.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,871,723.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	230,000.00	1,267,277.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>12,015,074.29</u>	<u>147,155,797.32</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	127,653,754.00	458,027,954.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,584,400.00	110,359,494.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,584,400.00	110,359,494.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,584,400.00	103,289,494.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,037,400.00	103,289,494.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,547,000.00	00.00
120009	Бусад орлого	00.00	7,070,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	117,069,354.00	347,668,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	114,310,000.00	306,766,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	114,310,000.00	306,766,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	40,902,060.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,498,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	28,404,060.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	759,354.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	759,354.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	106,707,696.82	447,551,078.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,707,696.82	447,551,078.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,707,696.82	419,975,552.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,372,528.00	273,375,764.50
210101	Үндсэн цалин	77,189,862.00	191,670,982.90
210102	Нэмэгдэл	00.00	47,467,956.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,375,666.00	18,080,100.00
210104	Урамшуулал	00.00	16,156,725.60
210105	Гэрээт ажлын хөлс	807,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,069,213.21	33,043,312.71
210201	Тэтгэврийн даатгал	8,820,659.27	18,521,170.60
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,985,927.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,800,389.08
210204	Ажилгүйдлийн даатгал	248,553.94	511,677.03
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,224,149.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,503,229.10	23,145,463.19
210301	Гэрэл, цахилгаан	3,111,584.10	11,244,775.80
210302	Түлш, халаалт	5,216,758.00	11,069,248.00
210303	Цэвэр, бохир ус	174,887.00	831,439.39
2104	Хангамж, бараа материалын зардал	1,893,996.51	9,670,051.15
210401	Бичиг хэрэг	338,250.00	1,645,504.00
210402	Тээвэр, шатахуун	480,000.00	2,088,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	449,733.51	1,410,970.15
210404	Ном, хэвлэл	00.00	104,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	470,313.00	2,339,765.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	155,700.00	2,080,502.00
2105	Нормативт зардал	00.00	3,075,800.00

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,075,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	975,340.00	14,716,330.00
210604	Урсгал засвар	975,340.00	14,716,330.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,587,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,587,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,893,390.00	30,434,271.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,539,870.00	27,688,455.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	70,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,320.00	1,348,200.00
210807	Газрын төлбөр	00.00	236,016.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200.00	32,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	30,927,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	29,927,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	27,575,525.45
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	19,976,825.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	7,598,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,598,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>20,946,057.18</u>	<u>10,476,876.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,476,876.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,476,876.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,476,876.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,476,876.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-10,476,876.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,946,057.18	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,946,057.18	00.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,969,025.00	24,925,659,841.00	-175,170,826.38	27,036,458,039.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,285,969,025.00	24,925,659,841.00	-175,170,826.38	27,036,458,039.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			12,015,074.29	12,015,074.29
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,969,025.00	24,925,659,841.00	-200,636,543.23	27,010,992,322.77
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,969,025.00	24,925,659,841.00	-200,636,543.23	27,010,992,322.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,285,969,025.00	24,925,659,841.00	-200,636,543.23	27,010,992,322.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		808,654,429.52		808,654,429.52
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	86,843,200.00	00.00	147,155,797.32	233,998,997.32
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,372,812,225.00	25,734,314,270.52	-53,480,745.91	28,053,645,749.61

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	377,553,100.00	368,746,013.95	8,807,086.05	98%
УРСГАЛ ЗАРДАЛ	377,553,100.00	368,746,013.95	8,807,086.05	98%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,954,400.00	361,147,313.95	8,807,086.05	98%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,522,500.00	258,205,460.90	6,317,039.10	98%
Үндсэн цалин	192,543,300.00	191,670,982.90	872,317.10	100%
Нэмэгдэл	46,800,700.00	47,467,956.00	-667,256.00	101%
Унаа хоолны хөнгөлөлт	24,192,000.00	18,080,100.00	6,111,900.00	75%
Урамшуулал	986,500.00	986,422.00	78.00	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,462,700.00	31,237,552.71	1,225,147.29	96%
Тэтгэврийн даатгал	21,718,400.00	16,715,410.60	5,002,989.40	77%
Тэтгэмжийн даатгал	2,686,100.00	3,985,927.00	-1,299,827.00	148%
ҮОМШӨ-ний даатгал	2,148,900.00	2,800,389.08	-651,489.08	130%
Ажилгүйдлийн даатгал	537,200.00	511,677.03	25,522.97	95%
Эрүүл мэндийн даатгал	5,372,100.00	7,224,149.00	-1,852,049.00	134%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,624,600.00	23,145,463.19	479,136.81	98%
Гэрэл, цахилгаан	11,691,400.00	11,244,775.80	446,624.20	96%
Түлш, халаалт	11,088,000.00	11,069,248.00	18,752.00	100%
Цэвэр, бохир ус	845,200.00	831,439.39	13,760.61	98%
Хангамж, бараа материалын зардал	8,760,300.00	8,751,756.15	8,543.85	100%
Бичиг хэрэг	1,244,400.00	1,645,504.00	-401,104.00	132%
Тээвэр, шатахуун	1,611,600.00	1,688,410.00	-76,810.00	105%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,088,000.00	1,410,970.15	677,029.85	68%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,205,000.00	2,339,765.00	-134,765.00	106%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,611,300.00	1,667,107.00	-55,807.00	103%
Нормативт зардал	3,084,000.00	3,075,800.00	8,200.00	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,084,000.00	3,075,800.00	8,200.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	12,432,600.00	12,418,180.00	14,420.00	100%
Урсгал засвар	12,432,600.00	12,418,180.00	14,420.00	100%
Томилолт, зочны зардал	1,675,200.00	1,587,000.00	88,200.00	95%
Дотоод албан томилолт	1,675,200.00	1,587,000.00	88,200.00	95%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,392,500.00	22,726,101.00	666,399.00	97%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,494,700.00	20,127,285.00	367,415.00	98%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	00.00	100%

Дүрслэх урлагийн музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Даатгалын үйлчилгээ	170,000.00	59,400.00	110,600.00	35%
Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	70,100.00	9,900.00	88%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00	20,000.00	0%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,222,000.00	1,201,200.00	20,800.00	98%
Газрын төлбөр	350,000.00	236,016.00	113,984.00	67%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	55,800.00	32,100.00	23,700.00	58%
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	00.00	0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7598700.00	7598700.00	00.00	100%
Бусад урсгал шилжүүлэг	7,598,700.00	7,598,700.00	00.00	100%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,598,700.00	7,598,700.00	00.00	100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,553,100.00	368,746,013.95	8,807,086.05	98%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	306,766,400.00	294,170,838.95	12,595,561.05	96%
Улсын төсвөөс санхүүжих	306,766,400.00	294,170,838.95	12,595,561.05	96%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	70,786,700.00	74,575,175.00	-3,788,475.00	105%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,786,700.00	74,575,175.00	-3,788,475.00	105%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	0%
БУСАД ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	00.00	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	0%
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0	0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32	0	100%
Удирдах ажилтан	1	1	0	100%
Гүйцэтгэх ажилтан	15	15	0	100%
Үйлчлэх ажилтан	16	16	0	100%
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32	0	100%
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	20	20	0	100%
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0	100%
Гэрээт ажилтан	2	2	0	100%

4.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,901,054.60	40,901,054.60	00.00	100%
УРСГАЛ ЗАРДАЛ	40,901,054.60	40,901,054.60	00.00	100%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,901,054.60	40,901,054.60	00.00	100%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,170,303.60	15,170,303.60	00.00	100%
Урамшуулал	15,170,303.60	15,170,303.60	00.00	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,805,760.00	1,805,760.00	00.00	100%
Тэтгэврийн даатгал	1,805,760.00	1,805,760.00	00.00	100%
Хангамж, бараа материалын зардал	918,295.00	918,295.00	00.00	100%
Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00	00.00	100%
Ном, хэвлэл	104,900.00	104,900.00	00.00	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	413,395.00	413,395.00	00.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	12,080,700.00	12,080,700.00	00.00	100%
Багаж, техник, хэрэгсэл	9,017,700.00	9,017,700.00	00.00	100%
Тавилга	563,000.00	563,000.00	00.00	100%
Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	00.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,039,000.00	8,039,000.00	00.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,892,000.00	7,892,000.00	00.00	100%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	147,000.00	147,000.00	00.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	2886996.00	2886996.00	00.00	100%
Бараа үйлчилгээний бусад зардал	1,886,996.00	1,886,996.00	00.00	100%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	00.00	100%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	00.00	0%
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00	00.00	0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40901054.60	40901054.60	00.00	100%
Нэмэлт санхүүжилтийн орлого	40,901,054.60	40,901,054.60	00.00	100%
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,498,000.00	12,498,000.00	00.00	100%
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,403,054.60	28,403,054.60	00.00	100%
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			00.00	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				0%

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дүрслэх урлагийн музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.15			САГ-2019/380/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дүрслэх урлагийн музей		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Ээлжийн амралтын тооцоог давтан шалгахад 18 ажилтанд 454.8 мянган төгрөг илүү, 3 ажилтанд 471.9 мянган төгрөг дутуу олгосон.	454.8	Төлбөрийн акт тогтоох	Ерөнхий менежер Нягтлан бодогч	У.Сарантуяа Б.Ану
2	Танхимын түрээсийн орлогод 12 харилцагчаас 10,950.0 мянган төгрөгийн түрээсийн орлого олсон. Гэхдээ эдгээр түрээсийн орлогууд нь тогтмол биш 2 цагаас 7 өдрийн хугацаагаар түрээслүүлсэн шалтгаанаар ТӨБЗГ-ын гэрээний үлгэрчилсэн загварыг ашиглаагүй, 30 хувь 3,285.0 мянган төгрөгийг шилжүүлээгүй.	3,285.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий менежер Нягтлан бодогч	У.Сарантуяа Б.Ану
3	Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 2,242,477.2 мянган төгрөгөөр тусгагдсан байхад санхүүгийн байдлын тайланд засгийн газрын оруулсан капиталын дүн 2,372,812.2 мянган төгрөгөөр тусгагдаж 130,335.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.		Зөвлөмж өгөх	Ерөнхий менежер Нягтлан бодогч	У.Сарантуяа Б.Ану
	Дүн	3,739.8			